



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 4638

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах
Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Эрх шилжүүлэх тухай” А/478 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Экскаватор 210 /базагч, молдок, соёо/” нийлүүлэх ГУББГ-06/2021 дугаартай нийлүүлэгчээр сонгон шалгарсан “Говь экуйпмент рентал флийт” ХХК-аас нийлүүлэх хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Геодези, Усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-т нийлүүлэгдэж буй Экскаватор 210 маркийн машин механизмыг дагалдах хэрэгслийн хамт тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Н.Мөнхбаатар)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000719

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 18 -ны өдрийн 0038 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	М.Мандах	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Хатанбаатар	“Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-ын Нийтлэг үйлчилгээ эрхэлсэн Орлогч дарга /зөвшилцсөнөөр/
	П.Мөнхдэлгэр	“Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-ын Тээвэр үйлчилгээний албаны дарга /зөвшилцсөнөөр/
	Х.Баттуяа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Эрдэнэмөнх	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн